



## ХӨДӨӨ АЖ АХҮЙН ИХ СУРГУУЛЬ АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
22 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243  
И-мэйл: agroecology@muls.edu.mn  
Вэб сайт: www.muls.edu.mn

2023. 09. 28 № 01 / 266  
танай -ны № -т

МУИС, ХШУИС, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН,  
ОЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТЭНХИМД

### Санал хүргүүлэх тухай

#### “ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ”

#### Хичээлийн стандарт хөтөлбөрт санал өгөх нь

Тус сургуулийн Экологийн тэнхимд Хүрээлэн бүй орчны хяналт, үнэлгээ, Экологи хөтөлбөрүүдээр магистрын сургалт явуулдаг бөгөөд бидний бэлтгэж буй мэргэжилтэнд байх ёстой ур чадварын нэг бол Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах ур чадвар юм. “Хүрээлэн бүй орчны менежмент” нэртэй энэхүү хичээлийн сэдвүүд доторх агуулга дээр менежментийн төлөвлөгөө боловсруулах гэсэн дэд сэдвийг нэмэх эсвэл ерөнхий ур чадварын хэсэгт оруулж өгөх нь зүйтэй. “ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ” хичээл нь Төрийн өмчийн сургуулийн оюутнууд хичээл сонгон судлах боломж гарч байгаа өнөө үед сонирхсон оюутнуудад хэрэгтэй хичээл юм. Хичээлийн стандарт хөтөлбөрт доорх засваруудыг хийх санал өгч байна.

- Хичээлийн зорилгыг товч тодорхой болгох
- Хичээлийн агуулга хэсэгт хичээлийн хөтөлбөр нь 10 хэсгээс бүрдэнэ гэсэн боловч, англи хэлээр бичихдээ 14 гэж бичсэнийг нягтлах
- Хүрээлэн бүй орчны менежмент хичээл нь Хүрээлэн бүй орчин судлал, Хүрээлэн бүй орчны мониторинг хичээлүүдийн залгамж холбоо учраас агуулга давхцуулахгүй байх өөрөөр хэлбэл орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ерөнхий мэдээллийг өгөх биш хүрээлэн бүй орчны үндсэн бүрэлдэхүүн хэсэг бүрийн нөөцийн хэмжээ, хэрхэн зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнгүүдэд түшиглэн явуулах нь зөв юм.
- Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, дадал хэсэгт “Хүрээлэн бүй орчны менежментийн суурь мэдлэгийг эзэмшихийн зэрэгцээ түүнийг судалгаанд хэрэглэх дүн шинжилгээний арга зүйд суралцаж, ашиглах чадвар, дадлыг олж авна” гэхийн оронд “Хүрээлэн бүй орчны менежментийн мэдлэгийг эзэмшсэнээр судалгаа шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэж, менежмэнтэд үр ашигтай, оновчтой ашиглах чадвар, дадлыг олж авна” гэж бичих нь зөв болов уу. Энэ хичээлийг үзээд оюутан ямар ур чадвартай болох вэ гэхээр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах

чадвартай болох болов уу. Сэдвүүд дээр менежментийн төлөвлөгөө боловсруулах гэсэн дэд сэдийг нэмэх эсвэл өрөнхий ур чадварын хэсэгт оруулж өгөх

5. Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө хэсэгт

2-р долоо хоногт: хичээлийн сэдэв нь “Газрын доорх нөөцийн менежмент” байвал ямар вэ. “Дэлхийгээс чулуулаг, ашигт малтмал олборлох” гэснийг “Ашигт малтлалын нөөц, олборлолт” гэж засах

5-р долоо хоногт: хичээлийн сэдвийн агуулга дахь “Хөрсний бүтэц, Ургамлын өсөлтөд шаардлагатай хөрс, Хөдөө аж ахуйн төрлүүд” гэсэн дэд сэдвүүдийн оронд “Хүнсний аюулгүй байдал, тэжээлийн хангамжийн тухай ойлголт, Шим тэжээлийн бодисын эргэлтийг загварчлах” гэсэн сэдвүүд байх нь магистр, докторын шатны сургалтанд илүү ахисан түвшний мэдлэг олгох болов уу

7-р долоо хоногт: хичээлийн сэдвийн агуулга дахь “Олон зориулалттай далангийн төслүүд” гэсэн сэдэв илүүц юм. Олон улсад далан барих биу буулгах аргаар голын нөхөн мэргээлт хийх ажлууд орчин үед түлхүү хийгдэж байна. Мөн “Устай холбоотой өвчин” гэсэн дэд сэдвийг “Усны бохирдлын нөлөө” гэсэн дэд сэдэв рүү нийлүүлэн (агуулгын давхардал гарах учир), “Цэвэр усны бохирдлыг бууруулах” гэснийг “Усны бохирдлыг бууруулах технологи” болгох

8-р долоо хоногт: хичээлийн сэдэв нь “Байгалийн аюулыг зохицуулах” гэснийг “Эрсдэлийн менежмент болгох, доторх дэд сэдвүүд нь эрсдэлийг үнэлэх, даван туулах зэрэг байх хэрэгтэй.

10 болон 11-р долоо хоногт тавигдсан сэдвүүд хичээлийн эхэнд орвол дараалал оновчтой болох болов уу. Ерөнхийдөө Дэлхийн хүн ам нэмэгдсэнээс үүдэлтэй хүнс тэжээл, дулаан хангамж бусад олон хэрэгцээ нэмэгддэг учраас хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах эрхийг хангахын зэрэгцээ байгалийн нөөцийг хадгалах, хамгаалах ур ухааныг гаргах, зохицуулалт хийхийг хүрээлэн буй орчны менежмент гэж үзэж байгаа учраас логик хичээлийн сэдвүүдийн логик дарааллыг оновчтой байрлуулах хэрэгтэй.

6. Семинарын хичээлүүдийн сэдэв доторх агуулгыг яг юу хийлгэх гэж байгаа вэ гэдгээ тодорхойлж бичсэн нь сайн талтай боловч сэдвүүдийг оновчтой уг хэллэгээр илэрхийлэх хэрэгтэй. Жишээ нь “Хэрэглээний болон худалдааны ХАА хэлбэрүүд, сайн муу жишээ кейс” гэхийн оронд “Өрхийн болон үйлдвэрлэлийн зориулалттай загвар тариалангийн аж ахуйн жишээ” гэх мэт.

Санал, зөвлөмжийг хүлээн авч хамтран ажилласанд баярлалаа.

ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн

Экологийн тэнхимийн эрхлэгч  Т.Байгал-Амар доктор